



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
худалдан авах гэрээний үлгэрчилсэн
загварыг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагатай байгуулах “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан гэрээний үлгэрчилсэн загварын дагуу эрүүл мэндийн байгууллагуудтай “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ” болон “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-г шинэчлэн байгуулах үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны “Эрүүл мэндийн даатгалын гэрээний үлгэрчилсэн загварыг батлах тухай” 12 дугаар тогтоол, 2020 оны “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай” 12 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Л.Номин/-нд даалгасугай.

ДАРГА



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн
13 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВАГЧ:

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

ЭМДЕГ-ЫН ДАРГА

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ:

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

ЭМБ-ЫН ДАРГА, ЗАХИРАЛ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

202... оны.. дугаар
сарын ..-ны өдөр

Дугаар

.....хот/аймаг

Нэг талаас регистрийн дугаартайЭрүүл мэндийн байгууллага (цаашид “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч” гэх) нөгөө талаас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (цаашид “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч”, хамтад нь “талууд” гэх) нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг нэг жилийн хугацаатай байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн тусгай зөвшөөрөлд бичигдсэн үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээ, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.13-т заасан, хүний эрүүл мэндийн хэрэгцээ

шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд анагаах ухааны нотолгоонд суурилсан аргаар, чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч нь иргэн-даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээг “чанарын болон төлбөр”-ийн хяналт, гүйцэтгэлд үндэслэн худалдан авахтай холбогдох харилцааг зохицуулна.



1.2. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль холбогдох бусад хууль, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан журам заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.

1.3. Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд, эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.

1.4. Дор дурдсан баримт бичиг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг (цаашид “гэрээний баримт бичиг” гэх) болно:

1.4.1. тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээг тогтоосон нэгдүгээр хавсралт;

1.4.2. гэрээг дүгнэхэд харгалзах тусламж, үйлчилгээний тоо болон чанарыг хэмжих шалгуур үзүүлэлт бүхий хоёрдугаар хавсралт;

1.4.3. талуудын харилцах сувгийг тодорхойлсон гуравдугаар хавсралт;

1.5. Талууд гэрээтэй холбоотой асуудлаар зөвхөн албан ёсны хүрээнд харилцах ба үүнд энэхүү гэрээний гуравдугаар хавсралтад тодорхойлсон харилцах сувгаар цаасан ба цахим хэлбэрээр илгээсэн албан бичиг, төлбөрийн нэхэмжлэл, түүнчлэн тэмдэглэлээр баталгаажсан уулзалт хамаарна.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч дараах эрх эдэлнэ:

2.1.1. иргэн, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын дагуу чанарын болон төлбөрийн хяналт хийх;

2.1.2. Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 70 хувийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгон, үлдэгдэл 30 хувийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн бүтэн жилийн гэрээний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн олгох эсэхийг шийдвэрлэх;

2.1.3. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9, сум тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.13-т заасан тусламж, үйлчилгээний урьдчилгаа болгож,

өмнөх сарын гүйцэтгэлийн 70 хүртэлх хувиар тооцон, урьдчилгаа санхүүжилтийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгох;

2.1.4. гэрээний 2.1.3-ын дагуу олгосон тусламж, үйлчилгээний зардлын урьдчилгаа төлбөр нь шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийн дүнгээс давсан тохиолдолд зөрүүг дараа саруудын урьдчилгаа төлбөрөөс суутгах;

2.1.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, шүүхийн маргаан болон хяналтаар зөрчил илрүүлсэн тохиолдолд газар дээрх хяналт хийх, эмнэлзүйн аудит хийж, шинжээчээр дүгнэлт гаргуулах зэрэг хяналтын үйл ажиллагаанаас холбогдох арга хэмжээг авах;

2.1.6. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс холбогдох хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт, мэдээллийг шаардаж гаргуулах;

2.1.7. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын шалгуурыг хангаагүй тусламж, үйлчилгээний тохиолдлын төлбөрийг санхүүжүүлэхгүй байх ;

2.1.8. дараах тохиолдолд холбогдох баримт, нотолгоог үндэслэн тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг хянах болон санхүүжүүлэхээс татгалзах:

2.1.8.1. гэрээний 3.6.1, 3.6.2, 3.6.3, 3.6.4, 3.6.5, 3.6.6-т заасан шалтгаанаар гэрээг түдгэлзүүлэн шалгахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн буруутай нь нотлогдсон тохиолдолд энэ хугацаанд харгалзах тусламж, үйлчилгээний нэхэмжлэл;

2.1.8.2. гэрээний нэгдүгээр хавсралтаар баталсан, Эрүүл мэндийн даатгалын хуулийн 9.1.9-т заасан тусламж, үйлчилгээний тоо хэмжээнээс хэтэрсэн нэхэмжлэл;

2.1.8.3. Эрүүл мэндийн даатгалын хуулийн 9.1.9-т заасан тусламж, үйлчилгээний хувьд гэрээний 2.4.1-т заасан хугацаанаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцроосон нэхэмжлэл;

2.1.8.4. тусгай зөвшөөрөлд заасан хаяг, байршлаас өөр хаяг байршилд үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэл;

2.1.8.5. эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрөл эсхүл магадлан итгэмжлэлийн хугацаа нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр сунгагдахдаа уг хугацаа дуусгавар болсон өдрөөс нөхөж сунгагдсан тохиолдолд дээрх хугацаан дахь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-т заасан тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэл;

2.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч дараах үүрэг хүлээнэ:

2.2.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж, хяналтын үр дүнд суурилан шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийн хэмжээг тогтоох;

2.2.2. гэрээний 2.2.1-т заасан тооцооны үр дүнд үндэслэн нэхэмжлэлийн хяналт дууссанаас хойш холбогдох журамд заасан хугацаанд багтаан тусламж, үйлчилгээний төлбөрийн урьдчилгаа болон гүйцэтгэлийн зөрүүг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх;

2.2.3. а) төлбөрийн нэхэмжлэлийн хяналтын тайлан, б) эрүүл мэндийн байгууллага дээр хийх хяналт, гэрээний хэрэгжилтийг хянасан тухай дүгнэлт, с) эмнэлзүйн аудит хийсэн шинжээчийн дүгнэлт тус бүрийг хяналт дууссанаас хойш ажлын 5 хоногт тус тус багтаан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх;

2.2.4. нэхэмжлэлийн хяналтын талаар болон албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн талаар гаргасан гомдлыг гомдол хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан хянан үзэж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хариу хүргүүлэх;

2.2.5. тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын үр дүнд хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид зөвлөмж өгөх;

2.2.6. эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн сан, тусламж, үйлчилгээний чанар, зардлын төлбөрийн хяналттай холбоотой журам, шалгуур, аргачлал, удирдамж, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тухай бүр хүргүүлэх;

2.2.7. хөнгөлөлттэй эмийн жор бичих эмчийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, програмд нэвтрэх эрхийг цаг хугацаанд нь нээх;

2.2.8. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид эрүүл мэндийн даатгалын мэдээллийн санд хандах техникийн боломжийг олгох, системийн хөгжүүлэлт, хэвийн ажиллагааг хангах, мэдээлэл дамжуулах загварыг гаргах;

2.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч дараах эрх эдэлнэ:

2.3.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9, сум тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.13-т заасан тусламж, үйлчилгээний шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэх;

2.3.2. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэхэмжлэх;

2.3.3. тусламж, үйлчилгээний зардалд зориулж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас урьдчилгаа төлбөр нэхэмжлэх;

2.3.4. хяналтын тайлан, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлан, дүгнэлт хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт, эрүүл мэндийн даатгалтай холбоотой аливаа асуудлаар холбогдох тайлбар, гомдол, саналаа тусламж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид албан бичгээр хүргүүлэх;

2.3.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч байгууллагын цахим мэдээллийн сангийн зөвшөөрөгдсөн хэсэгт нэвтрэх, холбогдох мэдээллийг шаардах;

2.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч дараах үүрэг хүлээнэ:

2.4.1. тусламж, үйлчилгээний зардлын нэхэмжлэлийн мэдээллийг цахим системээр, албан бичгийг гэрээний баримт бичигт заасан холбогдох хаягаар эсхүл

орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсийн албан ёсны цахим хаягаар сар бүрийн 5-ны дотор хүргүүлэх;

2.4.2. төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуусталх хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид хүргүүлэх;

2.4.3. нарийвчилсан хяналт хийхээр сонгосон түүврийн жагсаалтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас хүлээн авснаас хойш ажлын 1 хоногт багтаан холбогдох маягтуудын дагуу гаргаж хүргүүлэх;

2.4.4. тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах зайлшгүй болон нэмэлт шаардлагыг гэрээний хугацаанд хангаж ажиллах. Хэрэв холбогдох шаардлагыг хангах боломжгүй болсон тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх;

2.4.5. хяналт шалгалт хийхэд шаардагдах баримт, нотолгоо, мэдээллийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид саадгүй гаргаж өгөх;

2.4.6. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас тогтоосон шаардлагад нийцүүлж цахим системээр мэдээлэл солилцох техникийн боломжийг бүрдүүлэх;

2.4.7. иргэн, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын мэдээллийг цахим системээр үнэн зөв алдаагүй илгээх;

2.4.8. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой хууль, тогтоомж, эрх зүйн акт болон даатгалаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ, түүний төлбөрийн мэдээллийг шинэчлэгдсэн тухай бүр иргэдэд ил тод мэдээлдэг байх;

2.4.9. иргэн, даатгуулагчийн эрүүл мэндийн болон тусламж, үйлчилгээний мэдээллийн нууцлалыг хадгалах;

2.4.10. иргэн, даатгуулагчид хөнгөлөлттэй олгох эмийн жор бичих;

ГУРАВ. ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ

3.1. Дараах тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна:

3.1.1. гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд эрх бүхий этгээдээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр (эрүүл мэндийн даатгалын сан болон даатгуулагчийн төлбөр)-ийн хэмжээг өөрчлөх шийдвэр гаргасан бол;

3.1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч энэхүү гэрээний Хавсралт 1-д заасан тусламж, үйлчилгээний жагсаалтад заагаагүй тусламж, үйлчилгээ шинээр үзүүлэх, эсхүл уг жагсаалтад заасан тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжгүй болсон тухай хүсэлтээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авагчид албан ёсоор ирүүлсэн бол;

3.1.3. хуульд заасан бусад үндэслэл.

3.2. Энэхүү гэрээний 3.1.1-д заасан шийдвэр гарснаас ажлын 5 хоногийн дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч гэрээний холбогдох заалт, хавсралтад өөрчлөлт оруулах мэдэгдлийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлж, гэрээнд өөрчлөлт оруулах хэлцлийг эхлүүлнэ;

3.3. Энэхүү гэрээний 3.1.2-т заасан тусламж үйлчилгээг гэрээний хавсралтаас хасуулах хүсэлтийг ажлын 5 өдөрт, бусад хүсэлтийг хуанлийн 30 хоногийн дотор шийдвэрлэнэ;

3.4. Талууд гэрээнд өөрчлөлт оруулах саналаа бичгээр гаргах бөгөөд санал гаргаснаас хойш нэг сарын дотор зөвшилцөл хийх ажлыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч зохион байгуулна.

3.5. Гэрээнд орсон өөрчлөлтийг талууд хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

3.6. Дараах тохиолдолд гэрээг түдгэлзүүлнэ:

3.6.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн Эрүүл мэндийн магадлан итгэмжлэл, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд гэрээг бүхэлд нь;

3.6.2. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч шалгах явцад эмнэлгийн алдаа, зөрчил илэрч, дахин нягтлан шалгах шаардлага гарсан тохиолдолд гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

3.6.3. эрх бүхий этгээдээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг нь хэсэгчлэн болон бүхэлд нь зогсоох шийдвэр гаргасан бол гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

3.6.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний холбогдох баримт бичгийн тодорхой хэсгийг түр түдгэлзүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд;

3.6.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас газар дээр нь хийсэн хяналт шалгалтаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч сонгон шалгаруулалтаар шаардсан тусгай шаардлагыг хангаагүй, эсхүл хуурамчаар бичиг баримт бүрдүүлж, гэрээнд заасан шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон бол гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

3.6.6. иргэн, даатгуулагчид хөнгөлөлттэй үнээр эм олгох жор бичих нөхцөл, шаардлагыг хангаагүй тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-т заасан тусламж, үйлчилгээг үзүүлэх, худалдан авахтай холбоотой гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

3.7. Дараах тохиолдолд нотлох баримтад үндэслэн гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг түдгэлзүүлснийг цуцлах эсэхийг шийдвэрлэнэ:



3.7.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс энэхүү гэрээний 3.6.1, 3.6.4-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн шалтгааныг шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид ирүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор;

3.7.2. энэхүү гэрээний 3.6.2, 3.6.3, 3.6.5, 3.6.6-д заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн шалтгааныг шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид ирүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор.

3.8. Дараах тохиолдолд гэрээний Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-тэй холбогдох тусламж, үйлчилгээг үзүүлэх, худалдан авахтай холбогдох харилцааг хугацаанаас нь өмнө цуцлах үндэслэл болно:

3.8.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн 70 буюу түүнээс дээш хувийг хангаагүй бол;

3.8.2. дараах зөрчлийн тохиолдол нийлбэр дүнгээрээ тухайн хугацаанд ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийн тоо хэмжээний эсхүл мөнгөн дүнгийн 10 хувьд хүрсэн бол:

3.8.2.1. хуурамч нэхэмжлэл илгээсэн;

3.8.2.2. завших оролдлого хийсэн;

3.8.2.3. оношийн код ахиулж нэхэмжилсэн.

3.8.3. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч гэрээг түр түдгэлзүүлсэн хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас тавьсан шаардлагыг тогтоосон хугацаанд хангаагүй бол;

3.8.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчийн зүгээс хийх хяналт шалгалтад саад учруулсан, хяналт шалгалтаас зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, зайлсхийсэн, хяналт шалгалтад нөлөөлөхийг оролдсон, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгаагүй, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, дахин давтан зөрчил гаргасан нь нотлогдсон;

3.8.5. хуульд заасан бусад үндэслэл;

3.9. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч гэрээг цуцлах шийдвэр гаргаснаас хойш ажлын 5 хоногийн дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид шийдвэрийг албан бичгээр хүргүүлнэ.

3.10. Талууд гэрээг харилцан тохиролцсоны үндсэн дээр дуусгавар болгож болно.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч гэрээний үүргийг биелүүлээгүй нь тогтоогдвол дараах хариуцлага хүлээнэ:

4.1.1. энэхүү гэрээний 2.1.2, 2.1.3, 5.3-т заасан төлбөрийг хугацаанаас хожимдуулж төлсөн тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүнгээс дараах хувь хэмжээгээр тооцож эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид алданги төлнө:

4.1.1.1. гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүн 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг ба түүнээс их бол нэхэмжилсэн үнийн дүнгийн 0.05 хувиар;

4.1.1.2. гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүн 500,000,000 (таван зуун сая) төгрөгөөс 1,000,000,000 (нэг тэрбум) хүртэл төгрөг бол нэхэмжилсэн үнийн дүнгийн 0.1 хувиар;

4.1.1.3. гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүн 500,000,000 (таван зуун сая) төгрөг хүртэл бол нэхэмжилсэн үнийн дүнгийн 0.2 хувиар.

4.1.2. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний нууцлалыг хангаагүй бол хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргийг биелүүлээгүй нь тогтоогдвол дараах хариуцлага хүлээнэ:

4.2.1. энэхүү гэрээний 3.6.5-д заасан үндэслэлээр гэрээг түр түдгэлзүүлэхээс өмнөх хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас төлсөн төлбөрийг нөхөн суутгана. Нөхөн суутгах графикийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч тогтоох бөгөөд төлбөр нь графикт хугацаанаас хэтэрсэн тохиолдолд нөхөн төлөх төлбөрийн дүнгээс хэтэрсэн хоног тутамд 0.1 хувьтай тэнцэх алданги тооцох;

4.2.2. энэхүү гэрээний 2.4.1-д заасан үүргээ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биелүүлээгүй тохиолдолд хоцроосон хоног тутамд холбогдох тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийн дүнгийн 0.5 хувиар тооцож суутгах;

4.2.3. эмнэлзүйн аудитын дүгнэлтээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн буруутай нь нотлогдсон тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний төлбөрийг нөхөн суутгах;

4.2.4. иргэн, даатгуулагчаас хууль бус төлбөр авсан нь тогтоогдвол иргэн, даатгуулагчид төлбөрийг буцаан төлүүлж, улсын байцаагчийн актыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу торгууль ногдуулах;

4.2.5. хөнгөлөлттэй эмийн жор бичих эрхгүй эмчээр жор бичүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад холбогдох хууль, журмын дагуу торгууль ногдуулах;

4.3. Энэхүү гэрээний 3.8-д заасан үндэслэлээр талуудын хооронд байгуулсан гэрээ цуцлагдсан тохиолдолд тухайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч дахин сонгон шалгаруулалтад оролцож, гэрээ байгуулах мэдэгдэл хүлээн авах хүртэл гэрээ байгуулах эрхгүй байна.

ТАВ. ГЭРЭЭГ ДҮГНЭХ

5.1. Энэхүү гэрээг эрх бүхий этгээдээс баталсан гэрээ дүгнэх аргачлал, журмын дагуу дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор дүгнэнэ,

5.2. Гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээний тайланг эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ.

5.3. Гэрээний хэрэгжилтийн үр дүнг үндэслэн, 90 хувь ба түүнээс дээш оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл болох 30 хувийг гэрээ дүгнэснээс хойш ажлын 10 хоногийн дотор олгоно.

ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1. Энэхүү гэрээтэй холбоотой талуудын хооронд үүссэн аливаа маргааныг дараах арга замаар шийдвэрлэнэ:

6.1.1. нэхэмжлэл, нэхэмжлэлийн хяналттай холбогдох маргааныг холбогдох журмын дагуу;

6.1.2. тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналттай холбоотой маргааныг талуудаас гаргасан нотолгоонд үндэслэн хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтээр;

6.1.3. хэрэв аль нэг тал маргааныг хэлэлцээ хийж шийдвэрлэхээр бичгээр хүсэлт тавьснаас хойш ажлын 10 хоногт, эсхүл энэхүү гэрээний 6.1.1, 6.1.2-т заасны дагуу талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол Захиргааны хэргийн шүүхээр;

6.2. Талууд энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан шийдвэрлэхэд зөвхөн албан бичгээр харилцсан харилцааг баримт, нотолгоо болгоно.

6.3. Гэрээ, гэрээний баримт бичигтэй холбогдох аливаа маргаан болон гэрээнд өөрчлөлт оруулах, хэлэлцээр хийх зэрэг гэрээний аливаа харилцаанд талууд өөрсдөө төлөөлөн оролцох бөгөөд уг харилцаанд гуравдагч талыг оролцуулахгүй.

ДОЛОО. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

7.1. Энэхүү гэрээ болон гэрээний баримт бичиг нь талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

7.2. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

(Албан тушаал, нэр)

(Гарын үсэг) _____

ТАМГА

(Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчийн хаяг)

(Утас, факсын дугаар)

(Албан тушаал, нэр)

(Гарын үсэг) _____

ТАМГА

(Тусламж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн хаяг)

(Утас, факсын дугаар)

(Харилцагч банкны нэр, дансны дугаар)



..... дугаар гэрээний Нэгдүгээр хавсралт




/эрүүл мэндийн тусламж, эрүүл мэндийн тусламж,
үйлчилгээ үзүүлэгчийн нэр/-ИЙН ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ, ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Тусламж, үйлчилгээний төрөл	ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан төлбөрийн хэмжээ, төгрөгөөр онд төлөвлөсөн тоо хэмжээ	
			Боломжит дээд хэмжээ	Заавал үзүүлэх тоо хэмжээ
1	2	3	4	5


...../эрүүл мэндийн тусламж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн нэр/-тэй
БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

..... дугаар гэрээний Хоёрдугаар хавсралт


№	Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт/Аргачлал	Олон улсын дундаж хэмжээ	Суурь түвшин	Хүрэх түвшин	Нийт гэрээнд эзлэх хувийн жин /оноо	Үнэлэх аргачлал	Мэдээллийг эх сурвалж
1	Нэг хүртлэх насны хүүхдийн бүрэн тунгийн хамралтын хувь	Тухайн жилд дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан 1 хүртэлх насны бүртгэлтэй хүүхдийн тоо*100%/Нэг хүртэлх насны дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдвал зохих бүртгэлтэй хүүхдийн нийт тоо	≥80%	Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.	Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.	5 оноо	Хүрэх түвшинд хүрсэн бол 5 оноо, хүрээгүй бол 0 оноо	ЭМХТөвийн дата
2	Жирэмсний хяналтад дөрөв ба түүнээс дээш удаа хамрагдсан эхийн хувь	Тухайн жилд жирэмсний хяналтад дөрөв ба түүнээс дээш удаа хамрагдсан эхийн тоо *100%/Нийт жирэмсний хяналтад хамрагдвал зохих эхийн тоо	≥85%	Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.	Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.	5 оноо	Хүрэх түвшинд хүрсэн бол 5 оноо, хүрээгүй бол 0 оноо	ЭМХТөвийн дата



3	<p>Анхдагч артерийн даралт ихсэх өвчин бүртгэгдсэн (130/80-аас дээш) нийт тохиолдолд артерийн даралтыг хэвийн хэмжээнд буулгасан (130/80-аас доош) тохиолдлын эзлэх хувь</p>	<p>Анхдагч артерийн даралт ихсэх өвчин (АД 130/80-аас дээш) оношлогдож, эмчилгээ эхэлсэн өдрөөс хойш артерийн даралт хэвийн хэмжээнд (АД 130/80-аас доош) тогтвортой буулгасан тохиолдлын тоо*100%/Тухайн жилд анхдагч артерийн даралт ихсэх өвчин оношлогдсон нийт тохиолдол</p>	≥95%	<p>Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.</p>	<p>Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.</p>	10 оноо	<p>Хүрэх түвшинд хүрсэн бол 10 оноо, хүрээгүй бол 0 оноо</p>	<p>ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн нэгж 11.11.22 ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн нэгж Дата</p>
4	<p>Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс лавлагаа шатлалын эрүүл мэндийн Байгууллага руу өвчтөн шилжүүлсэн тоо болон лавлагаа шатлалын Байгууллагад өрхийн эрүүл мэндийн төвөөс очсон өвчтөний тооны зөрүүний хувь хэмжээ 5 хувиас ихгүй байх</p>	<p>Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага руу өвчтөн шилжүүлсэн тоо болон лавлагаа шатлалын байгууллагад өрхийн эрүүл мэндийн төвөөс очсон өвчтөний тооны зөрүүний хувь</p>	≤5%	<p>Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.</p>	<p>Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.</p>	10 оноо	<p>Хүрэх түвшинд хүрсэн бол 10 оноо, хүрээгүй бол 0 оноо</p>	<p>ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн нэгж Дата</p>
5	<p>Тухайн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн</p>	<p>Тухайн жилдээ лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх</p>	≤25%	<p>Байгууллага бүрийн суурь түвшинг</p>	<p>Суурь түвшинг сайжруулж,</p>	10 оноо	<p>Хүрэх түвшинд хүрсэн</p>	<p>ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн нэгж Дата</p>


<p>бүртгэлтэй хүн амын иргэдээс өвчний учир үзүүлсэн өвчтөнөөс лавлагаа шатгалын эрүүл мэндийн байгууллагад илгээсэн Тохиолдлын тоо</p>	<p>Бичгээр илгээсэн Тохиолдлын тоо*100%/Тухайн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд өвчний учир үзүүлсэн нийт Тохиолдол</p>		<p>гэрээнд тусгана.</p>	<p>ОУ-ын Түвшинд хүргэхээр толгооно.</p>		<p>Бол 10 оноо, хүрээгүй бол 0 оноо</p>	
<p>Тухайн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд Бүртгэлтэй хүн амаас хамгийн багадаа нэг удаа анхан шатны тусламж, үйлчилгээ авсан иргэдийн эзлэх хувь</p>	<p>Тухайн жилдээ хамгийн багадаа нэг удаа анхан шатны тусламж, үйлчилгээ авсан Тохиолдлын тоо*100%/Тухайн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв бүртгэлтэй хүн амын тоо</p>	<p>≥80%</p>	<p>Байгууллага бүрийн суурь Түвшинг гэрээнд тусгана.</p>	<p>Суурь Түвшинг сайжруулж, ОУ-ын Түвшинд хүргэхээр толгооно.</p>	<p>10 оноо</p>	<p>Хүрэх Түвшинд хүрсэн бол 10 оноо, хүрээгүй бол 0 оноо</p>	<p>ЭМДЕГ-ын Нэхэмжлэли Дата</p>
<p>Нийт үзлэг дотор эзлэх гэрийн эргэлтийн хувь</p>	<p>Тухайн жилдээ нярай, хэвтрийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хийсэн гэрийн эргэлтийн Тохиолдлын тоо*100%/Тухайн жилдээ хийсэн нийт үзлэгийн тоо</p>	<p>≥30%</p>	<p>Байгууллага бүрийн суурь Түвшинг гэрээнд тусгана.</p>	<p>Суурь Түвшинг сайжруулж, ОУ-ын Түвшинд хүргэхээр толгооно.</p>	<p>5 оноо</p>	<p>Хүрэх Түвшинд хүрсэн бол 5 оноо, хүрээгүй бол 0 оноо</p>	<p>ЭМДЕГ-ын Нэхэмжлэли Дата</p>
<p>Уртodate тогтмол ашигладаг эмчийн хувь</p>	<p>Уртodate-л сард 2 ба түүнээс дээш удаа хандалт хийж, шаардлагатай материал</p>	<p>≥ 85%</p>			<p>5 оноо</p>	<p>Хүрэх Түвшинд хүрсэн бол 5 оноо,</p>	<p>Валтерс Клүверийн Тайлан</p>

		Уншсан эмчийн тоо*100% / Нийт эмчийн тоо						Хүрээгүй бол 0 оноо	
9	Амбулаторийн нэг үзлэгт ногдох дундаж хугацаа		≥10 минут	Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.	Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.	5 оноо	Хүрэх түвшинд хүрсэн бол 5 оноо, хүрээгүй бол 0 оноо	ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн дата	
10	Жор бичсэн нийт антибиотик дотор 2 дугаар эгнээний антибиотикийн эзлэх хувь хэмжээ	Тухайн жилдээ 2 дугаар эгнээний антибиотик бичсэн жорын тоо*100/антибиотик бичсэн нийт жорын тоо	30% ≥	Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.	Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.	5 оноо	Хүрэх түвшинд хүрсэн бол 5 оноо, хүрээгүй бол 0 оноо	ЭМДЕГ-ын хөнгөлөлттэй эмийн дата	
11	40 ба түүнээс дээш насны эрсдэлт бүлгийн хүн амын дунд хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижин өвчний илрүүлийн хувь	Хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижин өвчний шинэ тохиолдлын тоо*100 % / 40 ба түүнээс дээш насны, эрсдэлт бүлгийн хүн амын тоо	≥30%	Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.	Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.	10 оноо	Хүрэх түвшинд хүрсэн бол 10 оноо, хүрээгүй бол 0 оноо	ЭМДЕГ	



<p>12</p> <p>Хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижин өвчин оношилогдсон (өлгөн үеийн венийн судасны глюкозжсон гемоглобин нь 7 %-аас дээш) нийт тохиолдолд НbA1c - ийн хэмжээг 1 хувиар бууруулсан тохиолдлын эзлэх хувь</p>	<p>Хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижин өвчин (өлгөн үеийн венийн судасны глюкозжсон гемоглобин НbA1c нь 7 %-аас дээш)-тэй иргэдийн НbA1c -ийн хэмжээг 1 хувиар бууруулсан тохиолдлын тоо*100%/Тухайн жилд хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижинтэй нийт хүний тоо</p>	<p>≥80%</p>	<p>Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.</p>	<p>Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.</p>	<p>10 оноо</p>	<p>Хүрэх түвшинд хүрсэн бол 10 оноо, хүрээгүй бол 0 оноо</p>	<p>ЭМДЕГ</p>
<p>13</p> <p>Лавлагаа шатлалд илгээсэн иргэнийг эргүүлэн хяналтанд авсан хувь</p>	<p>Хяналтад авч тусламж, үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлсэн иргэний тоо*100% / Лавлагаа шатлалд илгээсэн иргэний тоо</p>	<p>≥80%</p>	<p>Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.</p>	<p>Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.</p>	<p>5 оноо</p>	<p>Хүрэх түвшинд хүрсэн бол 5 оноо, хүрээгүй бол 0 оноо</p>	<p>ЭМДЕГ</p>
<p>14</p> <p>40-өөс дээш насны эрсдэлт бүлгийн хүн амын дунд 1, 2 дугаар үе шатны хорт хавдрын илрүүлгийн хувь</p>	<p>1, 2 дугаар үе шатанд илрүүлсэн* хорт хавдартай иргэний тоо*100% / 40-өөс дээш насны эрсдэлт бүлгийн хүн амын тоо</p>	<p>≥50%</p>	<p>Байгууллага бүрийн суурь түвшинг гэрээнд тусгана.</p>	<p>Суурь түвшинг сайжруулж, ОУ-ын түвшинд хүргэхээр тогтооно.</p>	<p>5 оноо</p>	<p>Хүрэх түвшинд хүрсэн бол 5 оноо, хүрээгүй бол 0 оноо</p>	<p>ЭМДЕГ</p>

* Лавлагаа шатлалд илгээн илрүүлсэн тохиолдол багтана.



..... дугаар гэрээний Гуравдугаар хавсралт:



ТАЛУУДЫН ХАРИЛЦАХ СУВАГ

Харилцах асуудал	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчийн:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн:
1. Цахим хаяг:		
Тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, өртөг зардал, төлбөрийн аргын асуудлаар		
Сонгон шалгаруулалт, гэрээлэлт, гэрээний үр дүнгийн хяналтын асуудлаар		
Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын асуудлаар		
Санхүүжилт, төлбөр тооцоотой холбоотой асуудлаар		
Програм хангамжийн асуудлаар		
Бусад нийтлэг асуудлаар		
2. Шуудангийн хаяг:		